



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН
ТУШААЛ

2010 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 15.2.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Малын индексжүүлсэн даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөрийн нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Энэ тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /С.Мягмардаш/-т үүрэг болгосугай.

САЙД

С.БАЯРЦОГТ

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН
ХУРААМЖИЙН ОРЛОГО, НӨХӨН ТӨЛБӨРИЙН НЯГТЛАН БОДОХ
БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

"Малын Индексжүүлсэн Даатгал" төсөл (цаашид МИД гэх) нь уламжлалт даатгалын хэлбэрүүдээс ялгаатай нөөцийн санг бүрдүүлж, нөхөн төлбөрийг олгодог тул МИД-ын малын эрсдэлийн даатгалын хураамжийн орлого, зардал, Засгийн газраас олгож байгаа нөхөн төлбөрийн олговор, давхар даатгалын хураамжийн зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгэхэд энэхүү түр журмыг даатгалын компаниуд зааврыг мөрдөнө.

Хоёр. Малын эрсдэлийн даатгал (МЭД)-ын гэрээ байгуулахаас өмнөх борлуулалтын улирал эхлэхийн өмнөх бүртгэл

МИД-д Оролцогчийн хураамж (МИДОХ)-ийг даатгалын компаниас төлөх үед дараах бичилтийг хийнэ.

Дт Богино хугацаат хөрөнгө оруулалт
Кт Мөнгөн хөрөнгө

Даатгалын компанийн төлөөлөгчид МЭД-ын гэрээг борлуулахтай холбоотой урьдчилгаа зардлыг тооцоолж шилжүүлэн хүлээн зөвшөөрөх үед дараах бичилтийг хийнэ.

Дт Урьдчилж гарсан зардал
Кт Мөнгөн хөрөнгө

Гурав. МЭД-ын хураамжийн орлогын бүртгэл

Даатгалын компани нь малчинтай МЭД-ын гэрээ байгуулах үед дараах бичилтийг хийнэ.

Дт Мөнгөн хөрөнгө
Дт Дундын сан
Кт Урьдчилж орсон орлого

МЭД-ын хураамжийн орлогыг малчдаас цуглуулж, борлуулалт дууссаны дараа Төсөл хэрэгжүүлэгч нэгж (ТХН)- ээс гаргасан тайланг үндэслэж дараах бичилтийг хийнэ.

Дт Урьдчилж орсон орлого
Кт Даатгалын хураамжийн орлого

Даатгалын гэрээний борлуулалт дууссаны дараа ТХН-ээс гаргасан гэрээний тайланг үндэслэн олон улсын болон Засгийн газрын давхар даатгалын зардлыг тооцож Засгийн Газрын нөөцийн дансанд шилжүүлэх үед дараах бичилтийг хийнэ.

Олон улсын давхар даатгалд хамрагдсан нөхцөлд:

Дт Давхар даатгалын зардал
Кт Дундын сан

Засгийн Газрын давхар даатгалд хамрагдсан нөхцөлд

Дт Засгийн Газрын нөөцийн сангийн зардал
Кт Дундын сан

Даатгалын компаниас төлсөн МИДОХ-ийн бодит дүнг даатгалын гэрээний борлуулалт хийгдсний дараа гарган урьдчилан тооцоолсон хэмжээнээс их байх тохиолдолд ТХН илүү төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэрийг тухайн даатгалын компанид Малын даатгалын нөхөн төлбөрийн данс (МДНТД)-наас буцаан олгох ба бага байх тохиолдолд ТХН тухайн даатгалын компаниас дутуу төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэрийг МДНТД руу буцаан татаж авна. Тооцоолсон хэмжээг ТХН нь тухайн даатгалын компанийн тухайн жилийн борлуулалтын нийт дүнгээс хамааруулж тооцоолон гаргана.

Их байх тохиолдолд:

Дт Богино хугацаат хөрөнгө оруулалт
Кт Мөнгөн хөрөнгө

Бага байх тохиолдолд:

Дт Мөнгөн хөрөнгө
Кт Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэлийг Дундын сан руу шилжүүлэн хаана.

Дөрөв. МЭД-ын нөхөн төлбөр, зарлагын бүртгэл

Тайлант үеийн МЭД-ын нөхөн төлбөр нь Дундын сангийн дүнгээс бага гарсан тохиолдолд дараах бичилтүүдийг хийнэ.

Нөхөн төлбөрийг олгохдоо ТХН-ээс гаргасан тайлан дахь хуримтлуулсан орлого орж ирэх үед:

Дт Мөнгөн хөрөнгө
Кт Богино хугацаат Хөрөнгө оруулалт
Кт Дундын сангийн буцаалт

МЭД-ын Нөхөн төлбөрийг гэрээ байгуулсан малчдад шилжүүлэх үед:

Дт Нөхөн төлбөрийн зардал
Кт Мөнгөн хөрөнгө

Хүүгийн орлого орж ирэх үед:

Дт Мөнгөн хөрөнгө
Кт Хүүгийн орлого

Тайлант үеийн МЭД-ын нөхөн төлбөр нь Дундын нөөцийн сангийн дүнгээс давсан тохиолдолд дараах бичилтүүдийг хийнэ.

ТХН-ээс гаргасан тайлан дахь хуримтлуулсан орлого орж ирсэн нөхөн төлбөрийг олгох үед:

Дт	Мөнгөн хөрөнгө
Кт	Богино хугацаат Хөрөнгө оруулалт
Кт	Дундын сангийн буцаалт
Кт	Олон улсын давхар даатгалын буцаалт
Кт	Орлого (Засгийн газрын нөөц, Дэлхийн банкны нөхцөлт зээл)

МЭД-ын Нөхөн төлбөрийг гэрээ байгуулсан малчдад шилжүүлэх үед:

Дт	Нөхөн төлбөрийн зардал
Кт	Мөнгөн хөрөнгө

Хүүгийн орлого орж ирэх үед:

Дт	Мөнгөн хөрөнгө
Кт	Хүүгийн орлого

Тав. Бусад

Оролцогч даатгалын компаниуд баталсан тайлангуудыг маягтаар ТХН-д заасан хугацаанд хүргүүлнэ.